

## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 36 ДУГААР ХУРАЛДААНЫ ТОЙМ

Хуралдаан 2013 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 15 цаг 33 минутад эхэлж, 16 цаг 58 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 25 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын дэд даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гаргуулах тухай	<p>Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Зургаанжингийн Энхболд, Ганболдын Чинзориг нарыг Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын дэд даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх.</p> <p>2. Энэ тогтоолын нэгдүгээрт нэр заасан иргэн Зургаанжингийн Энхболдыг Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын дэд даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэгт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>

2	<p>Удирдах албан тушаалд томилуулахаар санал болгосон албан хаагчдад Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p> <ul style="list-style-type: none"> <li>- Сангийн яамны Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газрын дарга</li> <li>- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Нийгмийн даатгал ерөнхий газрын Тэргүүн дэд дарга</li> </ul>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Сангийн яамны Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газрын даргын албан тушаалд Буянтгогтохын Нямаад дүгнэлт гарган нэр дэвшүүлж, томилуулахаар Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Ганцогтод санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Тэргүүн дэд даргын албан тушаалд Дондогдоржийн Золжаргалд дүгнэлт гарган нэр дэвшүүлж, томилуулахаар Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
---	--	--

3	Худалдан авах ажиллагааны газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан дэд даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд нээлттэй зарлах	Монгол Улсын Шадар сайд Д.Тэрбишдагвын 2013 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн ЗГ-2/358 тоот албан бичгээр Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан дэд даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирсний дагуу сонгон шалгаруулалтыг 2013 оны 12 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2014 оны 01 дүгээр сарын 16-17-ны өдрүүдэд зохион байгуулахаар тогтлоо.
4	Архангай аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилох тухай	Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “Гурав”-ын 3.3, Архангай аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2013 оны 67 тоот албан бичгээр ирүүлсэн санал, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн: 1. Архангай аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар тус аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн хүний нөөцийн бодлого хариуцсан мэргэжилтэн Пүрэвээгийн Бат-Эрдэнийг томилох. 2. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 141 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 1 дүгээрт заасан “...Цолмонгийн Баясгаланбаатар” гэснийг хүчингүй болсонд тооцох. 3. Салбар зөвлөлийн үйл

		ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэхийг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга П.Бат-Эрдэнэд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов
5	Сүхбаатар аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилох тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “Гурав”-ын 3.3, Сүхбаатар аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2013 оны 23, 29 тоот албан бичгээр ирүүлсэн санал, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <p>1. Сүхбаатар аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар тус аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн хүний нөөцийн бодлого хариуцсан мэргэжилтэн Мөнхтөмөрийн Мөнхцэцэгийг томилох.</p> <p>2. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 141 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 15 дугаарт заасан “...Үржингийн Мөнхбат” гэснийг хүчингүй болсонд тооцох.</p> <p>3. Салбар зөвлөлийн үйл ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэхийг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга М.Мөнхцэцэгт даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>

6	Зарим хүмүүсийг "Төрийн албаны тэргүүний ажилтан тэмдэг"-ээр шагнах тухай	<p>Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн албаны тэргүүний ажилтан тэмдгээр шагнах журам"-ын 3.3 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд гаргасан шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны чиг үүрэг, албан үүргээ үнэнч шударга, идэвх санаачилгатай, үр бүтээлтэй гүйцэтгэж, тогтвортой амжилт гарган төрийн албаны үйл хэрэгт бодитой хувь нэмэр оруулсан дараах нэр бүхий 25 төрийн албан хаагчдыг Монгол Улсын "Төрийн албаны тэргүүний ажилтан" тэмдгээр шагнах. Шагнагдсан хүн тус бүрийн тэмдгийг дагалдах мөнгөн шагнал (хоёр зуун мянган төгрөг)-ыг Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн албаны тэргүүний ажилтан тэмдгээр шагнах журам"-ын 4.2-т заасны дагуу шагнагдагсдад тухайн байгууллагаас олгох.</p> <p>2. Шагнагдсан нийт төрийн албан хаагчдад баяр хүргэж, ажлын амжилт хүсэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
7	Бусад асуудал:/Эрүүл мэндийн яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлөөс зохион байгуулж байгаа сонгон шалгаруулалтын тухай/	<p>Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "...шударга ёс..., тэгш байдал, ...хууль дээдлэх нь төрийн албаны үндсэн зарчим мөн", мөн зүйлийн 4.2-ийн 4.2.2-т "ил тод байх", 4.2.4-т "иргэд хуульд заасан болзол, журмын дагуу төрийн албанд орох адил тэгш боломжтой байх" гэсэн зарчим, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 60 дугаар тогтоолоор баталсан "Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон</p>

		<p>шалгаруулах журам”-ын 3.1-д “Салбар зөвлөл болон аймаг, нийслэлийн Боловсролын газар нь сонгон шалгаруулалт явуулахаас 21-ээс доошгүй хоногийн өмнө тухайн албан тушаал (ажлын байр)-ын сул орон тоог хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ”, 4.2-т “Сонгон шалгаруулалт явуулах тохиолдол бүрт комиссыг шинээр байгуулна” гэж заасныг баримтлан Гэмтэл согог судлалын үндэсний төвийн даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтыг зохион байгуулах нь зүйтэй гэж Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаас Эрүүл мэндийн яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлд үүрэг болгов.</p>
--	--	---

## **ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ**